



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдөр баталсан “Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын удирдамж”, дугаар 1/1222 албан тоотоор өгсөн үүргийн дагуу үер, усны ослоос сэрэмжлүүлэх 50 ширхэг, зам тээврийн ослын үед иргэдэд мэдээлэл өгөх 27 ширхэг, нийт 77 ширхэг самбарыг хулдаасан хэвлэлээр хэвлүүлж, 9 дүүргийн Онцгой байдлын хэлтсээс судалгаагаар ирүүлсэн газруудад байршуулсугай.

2. Самбарын байршлыг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах 552.750 (таван зуун тавин хоёр мянга долоон зуун тавин) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Самбарыг “Улаанбаатар Зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ-аас баталсан стандартад нийцүүлэн хэвлүүлэхийг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т, байршуулах ажлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан тэргүүн дэд дарга (дэд хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА  Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... тушаалын нэгдүгээр хавсралт

1117155601

УХА0033 9077073

ИРГЭДЭД МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ САМБАРЫН БАЙРШИЛ

1. Үер, усны ослоос сээрэмжлүүлэх самбар

д/д	Дүүрэг	Байршил	Нийт
1	Багануур дүүрэг	1.Хэрлэн голын эрэг, Ахмадын амралт 2. Цэвэршүүлэх станцын зүүн талд 7 дугаар худгын харалдаа 3. Хэрлэн тур амралтын газарт 4. Мэлз хайрхан уулын бэлд	4
2	Багахангай дүүрэг	1,2-р хороо тус бүрт 2 ш	4
3	Баянгол дүүрэг		2
4	Баянзүрх дүүрэг	1.Баянзүрх гүүрний зүүн талд 2.Баянзүрх гүүрний зүүн талд /Амралтын саравчтай хэсэг/ 3.Адам Евагийн хөшөөний урд талд 4.Хар усан тохой /2 самбар/ 5.Монгол шилтгээний баруун урд /Panorama hotel амралт/ 6.Гачуурт 85 дугаар сургуулийн урд 7. Хар усан тохойн зүүн үзүүр 8. Гачууртын гүүрний хажууд 9. Эко постны урд 10. Хар хошуу /2 самбар/ 11. Могойт дэнжийн урд 12. Минж үржүүлгийн газар /2 самбар/	15
5	Налайх дүүрэг	1.1-р хороо Их ам,Баянзүрхийн хэсэг 2. 6-р хороо Тэрэлжийн төв 3. 6-р хороо Шугуйн хэсэг 4. 1-р хороо Мойлтын тохой 5. 6-р хороо Байтаг богд 6. 6-р хороо Сайхны саравч	6
6	Сонгинохайрхан дүүрэг		5
7	Сүхбаатар дүүрэг	1.12-р хороо Сэлбэ гол 2. 13-р хороо Сэлбэ гол 3. 14-р хороо Сэлбэ гол 4. 17-р хороо Дамбын гүүр 5. 18-р хороо Бэлхийн гүүр 6. 19-р хороо Шаргаморьтын гүүр 7. 19-р хороо Майхан толгой	7
8	Хан-Уул дүүрэг		5
9	Чингэлтэй дүүрэг	1.12-р хороо Ногоон нуур цэцэрлэгт хүрээлэн 2. 19-р хороо Зуун модны зуслан	2
Нийт			50

2. Зам тээврийн ослын үед иргэдэд мэдээлэл өгөх самбар

д/д	Дүүрэг	Байршил	Тоо
1	Багануур дүүрэг	1.Хэрлэн шалган нэвтрүүлэх товчоо 2. Багануур хөшөөнөөс УБ руу гарах зам	2
2	Багахангай дүүрэг	УБ-Чойр чиглэлийн /A0101/ зам, Төв аймгийн Баян, Сэргэлэн сумдын хилийн зааг бүрт	2
3	Баянгол дүүрэг	1.20-р хороо Сонсголонгийн зам	2
4	Баянзүрх дүүрэг	1.Хонхор 11 дүгээр хороо Налайхын замд 2.Гачууртын замд	2
5	Налайх дүүрэг	1.5-хороо Бүс нуур	7

		2. 1- хороо А/24 постны цаана Тэрэлжийн уулзвар 3. 1-р хороо Сүүдрэвчтэй худалдааны төв 4. 1-р хороо Туулын гүүр 5. 6-р хороо Зуун ламын агуу 6. 6-р хороо Мэлхий хадны уулзвар 7. 6-р хороо Тэрэлжийн гарам	
6	Сонгинохайрхан дүүрэг	1.Баянголын ам 2. 21-р хороо Жаргалант тосгон	2
7	Сүхбаатар дүүрэг	1.18-р хороо Бэлх ХТ-ийн автобусны буудал 2. 19-р хороо Шаргаморьтын гүүр 3. 19-р хороо Санзайн ам 4. 19-р хороо Шаргаморьтын уулзвар 5. 20-р хороо Сэлхийн амны уулзвар 6. 20-р хороо Бэлхийн эцэст автобусны буудал	6
8	Хан-Уул дүүрэг	1.14-р хороо Өлзийт 2.13-р хороо Шувуун фабрик	2
9	Чингэлтэй дүүрэг	1.19-р хороо Гүнтийн даваа 2. 19-р хороо Шадивлан	2
Нийт			27

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны ...03... дугаар сарын ...12... -ны
өдрийн ...273... тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601
УХА0038 9077073

САМБАР ХЭВЛҮҮЛЭХЭД ШААРДАГ ДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

д/д	Төрөл	Тоо	Нэг самбарын хэмжээ /м ² /	Нийт хэмжээ /м ² /	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Үер, усны ослоос сэрэмжлүүлэх самбар	50	1,35	67.5	5500	371.250
2	Зам тээврийн ослын үед иргэдэд мэдээлэл өгөх самбар	27	1,22	33	5500	181.500
Нийт		77		100.5		552.750

-----000-----